



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар А/188

Булган сум

Төрийн захиргааны албан хаагчдад
зэрэг дэв олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2.3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам”-ын 2.5 дахь хэсэг, Төрийн албаны салбар зөвлөлийн 2025 оны 64 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2024 оны ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг “Маш сайн” үнэлгээтэй дүгнүүлсэн Эрүүл мэндийн газрын дарга Пүрэвжавын Оюунцэцэгт “Ахлах түшмэлийн дөтгөөр” зэрэг олгосугай.

2.Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэвийн нэмэгдлийг зохих журмын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн тооцож нөхөн олгохыг Эрүүл мэндийн газрын нягтлан бодогч (И.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6325811904

Сугар Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж